

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ГАДААДЫН БУЦАЛТГҮЙ  
ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

*(2016 оны жилийн эцсийн байдлаар)*

2017 оны 03 сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу байгаль орчин, аялал жуулчлалын салбарт гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн 2016 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгөв.

Хяналт-шинжилгээ үнэлгээг дүгнэхэд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжүүлэх төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, мэдээллийг үндэслэн тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан тогтоож, хяналтад авсан төслүүдийн биелэлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ өгч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх, бодит мэдээллээр хангах зорилгыг харгалзан үнэлэв.

***Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй***

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг удирдлага болгон, 2016 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй нийт 31 төслийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг нотлох, холбогдох материал судалгааг ашиглан, асуудал хариуцсан нэгжээс тайлбар, нэмэлт тодруулга авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулж бататган, тайлан, мэдээллийг үндэслэн удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан үнэлэв.

***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй нийт 31 төслийг хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлд үнэлгээ өгөв.

2016 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэл **88.1 хувьтай** буюу **4.4 оноотой** үнэлэгдэж, 4 төсөл 100% буюу бүрэн хэрэгжсэн, 11 төсөл 90 хувьтай, 13 төсөл 70 хувийн биелэлттэй, 1 төсөл 50 хувийн биелэлттэй дүгнэгдэж, гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад **0.7 хувийн өсөлттэй** дүгнэгдэв. Үнэлгээний дүнг хавсралт 1-д харуулав.

***Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй нийт 31 төслийн хүрээнд дор дурьдсан үр дүн, ололт амжилт, цаашид анхаарах асуудал гарсныг томъёолбол:

1. “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” төслийн хүрээнд:

Хөтөлбөрийн баримт бичигт тусгагдсан зорилтуудыг өгөгдсөн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд МУ-ын ойн салбарт ойн магадлан итгэмжлэл, ойн үрийн асуудал, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх бодит арга зам, зарчмууд бий болж, төрөөс баримтлах ойн бодлогод тусгагдсан нь төслийн томоохон ололт юм. Энэ ололт амжилтуудыг улсын хэмжээнд бүх төвшинд хэрэгжүүлэгч талуудад өргөн хэрэглээ практик болох ажлуудыг төслийн удирдах хороо болон БОАЖЯ-аас дэмжиж ажиллах шаардлагатай юм.

2. “Ил шаталтын үйл ажиллагаанд боломжит арга, технологи, байгаль орчинд ээлтэй практик нэвтрүүлэх бүсийн төсөл”-ийн хүрээнд:

Төслийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд болох БОАЖЯ болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хооронд санамж бичиг байгуулсан нь цаашид төслийг амжилттай хэрэгжүүлэх, хамтран ажиллахад ихээхэн ач холбогдолтой болсон бөгөөд төслийн ололттой тал гэж үзэж байна.

Төсөл хэрэгжээд нэг жил болж байгаа бөгөөд одоогоор дутагдалтай болон анхаарах асуудлууд гаргаагүй болно. Бүсийн төслийг хэрэгжүүлэх баримт бичигт 2015 оны 5-р сард талууд гарын үсэг зурсан боловч төсөл хэрэгжүүлэгч зарим улс баталгаажуулаагүй, төслийн нэгж байгуулаагүй шалтгаанаар төсөл хэрэгжих хугацаа хойшилж 2016 оноос хэрэгжиж эхлээд байна.

### 3. “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төслийн хүрээнд:

Төслийн хэрэгжилтийн шатанд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хариуцах бүтэц, чадавхийг бэхжүүлсэн нь ололттой тал байлаа.

Дараах асуудлыг цаашид анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн асуудлыг орон нутгийн төсөвт суулгах асуудал тулгарч байна.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчлэл, өөрчлөлт батлагдахад хугацаа ихээхэн шаардагдаж байна.

### 4. “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” төслийн хүрээнд:

Монгол, Германы Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны ээлжит хэлэлцээр 2016 оны 11 сарын 24, 25-ны өдрүүдэд ХБНГУ-ын Берлин хотноо болж, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн хоёрдугаар үе шат ТХГН-ийн Баруун бүсэд хэрэгжихээр болж, нийт 6.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн санхүүжилтийг Герман улсын Засгийн газраас олгохоор болсон. Цаашид ТХГН-ийн менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт 7 сая еврог ХБНГУ-ын Засгийн газраас урьдчилсан байдлаар мэдэгдсэн нь ололттой тал болно.

Цаашид анхаарах асуудлууд: Монгол-Германы Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн гэрээний заалтууд Монгол улсад дагаж мөрдөгдөх хуулийн бусад заалтуудтай зөрчилдөж байдаг нь ажлын явцад байнгын саад учруулж байна. Тухайлбал: Хоёр Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт төслийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа бүтээгдэхүүн бүх төрлийн албан татвараас чөлөөлөгдөнө гэж заасан байдаг ч Онцгой албан татварын тухай хуультай нийцдэггүй.

Монгол улс хүлээсэн үүргийн хүрээнд нийт 6.65 тэрбум төгрөгийг 5 жилийн хугацаанд зарцуулах ёстой ч жил бүр төслийн хөрөнгө оруулалтын зардалд улсын төсвөөс гаргах хөрөнгө оруулалтын төсөв хангалттай тусгадаггүй. Энэ асуудалд Герман талаас маш их анхаарал тавьдаг тул 2018 оны төсөвт багадаа 1.5 тэрбум төгрөг суулгах талаар Сангийн яам холбогдох газрууд анхаарч ажиллах нь зүйтэй.

2014 оноос хойш яамны бүтэц удаа дараа өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төсөл хариуцсан дарга, мэргэжилтэнүүд солигдож, тухай бүр ажлаа танилцуулах, тайлагнах, нэгдсэн ойлголцолд хүрэх, данс тооцоо өөрчлөгдөх гэх мэт ажлын тайлан төлөвлөгөөнд ороогүй ажлууд гарч төсөл хэрэгжилтийн ажилд саад учруулж байна. Төрийн байгууллагын ажлын ерөнхий үйл явц маш их хугацаа шаардаж, хүндрэл учруулж байна. Тухайлбал: Зорилт 3-д тусгагдсан ажлууд яамны ажилтай уялдсан тул дагаж мөрдөх журам, стандарт, төлөвлөгөөг хүлээж цаг алдаж байгаа тохиолдол байна.

### 5. REDD+д нийцсэн Монгол Улсын Үндэсний Ойн Тооллого” төслийн хүрээнд:

Цаашид олон зорилтот ойн тооллогыг 5 жилийн давтамжтай үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлснээр ойн мониторингийн ажил бэхжих, үндэсний чадавхи тогтвортой байх нөхцөл бүрдэнэ.

### 6. Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төслийн хүрээнд:

Дараах ололттой талыг онцлон тэмдэглэвэл:

- Төсөл хэрэгжсэнээр Монгол орны ойн нийт нутгийг хамарсан тооллого, мониторингийн ажлыг олон улсын шаардлагад нийцсэн аргачлалаар гүйцэтгэх техникийн бааз болон хүний нөөцийн үндэсний чадавхи бий болсон.
- Монгол орны ойн төлөв байдлын үнэлгээний ил тод байдлыг хангах зорилгоор олон зорилтот үндэсний ойн тооллогын үр дүнг онлайн орчинд байршуулсан.

- Төрөөс ойн талаар баримтлах бодлого, түүний хэрэгжилтийг хангах богино болон дунд хугацааны хөтөлбөрт тусгах тэргүүлэх чиглэлийн арга хэмжээг ойн тооллогын үр дүнд тулгуурлан боловсруулсан.
- Ойн тооллогын мэдээнд тулгуурласан суурь судалгааны цогц хөтөлбөрийг их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хэрэгжих нөхцлөөр хангагдсан.

*Санамж бичиг:* Цөлжилт болон шар шороон шуургатай тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Солонгос улсын ойн ерөнхий газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт 2016 оны 07-р сарын 17-ны өдөр 2 тал гарын үсэг зуран баталгаажуулсан.

*Гэрээ:* 2016 оны 11-р сарын 17-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос улсын ойн ерөнхий газрын төлөөлөгчид, Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамтай Ногоон хэрэм төслийн ойжуулсан талбайг хүлээлгэж өгөх болон дараагийн шатны ажлыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах гэрээ байгуулсан.

*Талбай хүлээлгэж өгөх талаар:*

- 2016 оны 03-р сарын 21 өдрийн “Түр хороо, ажлын хэсэг байгуулах, ажлын даалгавар батлах тухай” БОНХАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Ажлын хэсэг байгуулан, төслөөр байгуулагдсан Мод үржүүлгийн газар, ойн зурвас ойжуулсан талбайг Монголын Засгийн газарт хүлээлгэж өгөх бэлтгэл ажлыг хангуулсан.
- 2016 оны 11-р сарын 22 өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар оруулан баталгаажуулсан, одоогоор Засгийн Газрын тогтоол гаргуулахаар бусад яамнаас санал аван нэгтгэн ажиллаж байна.

Улсын ойн санд хүлээн авсан ойн зурвасыг цаашид хариуцан ажиллах байгууллага нь тухайн аймаг, сум дундын Ойн анги байх болно. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Ойн ангийг чадавхжуулах бүтцийг тогтвортой байлгах, бэхжүүлэх, Төв аймгийн Лүн суманд Ойн ангийг шинээр бий болгох шаардлагатай юм.

#### 7. "Монгол Улсын ойн сангийн экологийн төрөл зүйлийн генийн сангийн хөгжил" төслийн хүрээнд:

Төслийн ололттой тал нь Төр-хувийн хэвшлийн хамтран ажиллах амжилттай жишээ болж чадаж байна. Төслийн хүрээнд байгуулсан мод үржүүлгийн газрыг бүсийн хэмжээний ойчдыг сургах боломжтой “сургалтын бааз” болгон өргөтгөх талаар талууд ярилцаж байгаа бөгөөд Монголын тал сунган хэрэгжүүлэх асуудлыг тавьж байгаа юм. Чехийн Гадаад хэргийн Дэд сайд Ноён М. Шашек болон Монголын Байгаль орчин, аялал жуулчлалын Дэд сайд Ц.Батбаяр нарын уулзалтын үеэр ярилцсанаар 2017 нэмэлт санхүүжилтыг олгон, “Домогт Шарын Гол” ХХК-ийн мод үржүүлгийн газрын эрчим хүчний эх үүсвэрийг хүчитгэх буюу нэмэлт нарны хавтангуудыг суурилуулах дэд төсөл хэрэгжүүлэхээр болсон.

Цаашид анхаарах асуудал: Монгол улсын хууль эрхзүйн орчин өндөр мэдлэгтэй мэргэшлийн эксперт авчран ажиллуулах асуудлыг ялгавартайгаар шуурхай шийддэггүйгээс Чехийн төслийн баг визийн холбогдолтой асуудалтай тулгаран, хүндрэл учирч байгаа бөгөөд цаашид визийн, түүний нэвтрэх хугацаа болон оролт гаралтын тоог хөнгөвчлөх шаардлагатай байна. Монголын талаас албан байгууллагын ажиллагсдын тоотой уялдуулан авах экспертийн тоонд босго тавьдаг нь асуудал үүсгэсээр байна.

Томоохон асуудлын нэг нь Шарын гол дах усны хомсдол юм. Худагт ус нийлүүлдэг гол түр ширгэсэн нь Чех, Монголын хоорондын гэрээний дагуу ойн бодлого зохицуулалтын газраас гэрээ хийн, худаг өрөмдүүлэх ажил удахгүй хийгдэнэ. Цаашид Шарын голын алтны хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн газрыг ойжуулах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. Учир нь уг газар нь ойн сан бүхий газар, голын эх тул байгаль орчны хувьд нэн эмзэг, ач холбогдолтой тул зөвхөн ойжуулалт хийгээд зогсохгүй, цианит, мөнгөн усны бохирдлоос нь цэвэрлэх ажлыг хийх нь зохистой юм. Мэргэжлийн хяналтын байгууллага болон байгаль орчны байцаагч нарын чадавхийг сайжруулах хэрэгтэй байна.

Монголын уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж буй байдлыг харгалзан үзэж, ойжуулалт болон гадаргын ус хамгаалах чиглэлээр томоохон төсөл хөтөлбөрийг ДБ, АХБ, Ногоон уур амьсгалын сан зэрэг эх үүсвэрүүдээс санхүүжүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

8. “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд:

Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд REDD(Ойн Хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах) чиглэлийн үйл ажиллагаа нь Монгол дахь UN-REDD хөтөлбөрийн баг бүрдэлт удааширнаас хойшлогдон тайлант хугацаанд тодорхой үйл ажиллагаа хэрэгжээгүй бөгөөд улмаар REDD+ болон Экосистемийн үйлчилгээний төлбөрийн асуудалтай холбоотой төлөвлөгдсөн арга хэмжээнүүд хойшлогдож дараа онд шилжсэн болно.

Төслийн дунд хугацааны үнэлгээний зөвлөмжид үйл ажиллагааны цар хүрээг шинэчлэн боловсруулж, санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудаар батлуулах ажлыг 2017 онд БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлэх болно.

9. “Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөр” төслийн хүрээнд:

2016 онд Хөтөлбөрийн үндсэн 4 зорилтуудад хүрэх суурь бүх нөхцлүүд хангагдсан. Хөтөлбөрийн баримт бичиг болон 2016 онд төлөвлөгөөнд төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдсэн гэж үзэж байна.

НҮБ-ийн төрөлжсөн байгууллагууд болон ЗГ-ийн журмууд зэрэгцэн үйлчилдэг нь Хөтөлбөрийн өдөр тутмын хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байна.(аль нэгээр нь дагнах)

10. “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг үүр амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн хүрээнд:

2016 онд нийт 4 удаагийн мониторинг хийгдэж орон нутагт хийгдэж байгаа ажлын үйл явцад үнэлгээ өгөх, зөвлөгөө, чиглэл өгөх ажил хийгдлээ. Уг ажилд БОАЖ-ын яамны Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагаа, санхүү, сав газрын зэрэг хэлтсийн холбогдох албан тушаалтнуудаас гадна НҮБХХ-ийн Байгаль орчны нэгжийн ахлагч, холбогдох ажилтнууд оролцсон. Түүнчлэн энэ оны 6 сард Дасан Зохицох Сан болон НҮБХХ-ийн Хамтарсан мониторингийн баг Увс аймагт ажиллаж төслийн үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцаж, “амжилттай сайн хэрэгжүүлсэн” үнэлэлт дүгнэлт өгсөн.

Тулгарч байсан хүндрэл, бэрхшээлүүд, тэдгээрийг хэрхэн шийдсэн талаар: УИХ-ын сонгуулийн үр дүнтэй холбогдон Засгийн газар, яамдын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт гарсантай холбогдуулан төслийн удирдах зөвлөлийн дарга, төслийн үндэсний захирал болон орлогч захирал шинээр томилогдоход бага зэргийн хугацаа шаардагдсан ч төслийн ажлын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлээгүй болно.

Төслийн зарим ажлууд оройтох, хойшлох гэх мэт асуудлууд байсан бөгөөд төслийг хэрэгжүүлэгч, хамтрагч талуудын ойлголцол, нягт хамтын ажиллагаа, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хамтын хүчин чармайлтын үр дүнд ажлын гүйцэтгэл төлөвлөсний дагуу амжилттай хэрэгжсэн.

11. “Монгол улсад Полихлорт Бифенилийг байгаль орчинд ээлтэй аргаар устгах менежментийн чадавхийг бий болгох” төслийн хүрээнд:

Дүгнэлт: Энэхүү төсөл амжилттай хэрэгжиж дуусах шатандаа байгаа бөгөөд төслийн үндсэн зорилго, зорилтууд бүрэн биелсэн. Одоогийн байдлаар төслийн хүрээнд зорьсон 1000 тонн ПХБ-ээр бохирдсон төхөөрөмж цэвэрлэж дуусахад 250 орчим тонн дутуу байна. Цэвэрлэх ажиллагаа нь эрчим хүчний салбарын улирлын шинж чанартай засвар үйлчилгээ, таслалтын хуваариас шалтгаалан удаашралтай байгаагаас төсөл хэрэгжих хугацааг сунгасан.

Монгол улсад химийн бодисын бохирдлыг цэвэрлэхэд олон улсын техник технологи нэвтрүүлсэн анхны төсөл бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, зөвлөх мэргэжилтнүүдийн техникийн туслалцаа, туршлага, зөвлөгөө чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэж байна.

Эрчим хүч болон байгаль орчны салбар дахь үндэсний хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол төслийг амжилттай хэрэгжүүлэх гол үндэс болсон.

Төсөл хэрэгжсэнээр Монгол улс ПХБ-ийг байгаль орчинд ээлтэй аргаар устгах менежментийн чадавхитай болсон явдал бөгөөд энэхүү системээ ашиглан Удаан задардаг органик бохирдуулагчдын тухай Стокгольмын Конвенцоор хүлээсэн үүргийнхээ дагуу 2020 он гэхэд ПХБ-г бүрэн цэвэрлэх дуусгах юм.

Цаашид анхаарах асуудал нь төсөл хэрэгжиж дууссанаас хойш ПХБ цэвэрлэх цех, техник технологи, лабораторын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэн ПХБ цэвэрлэх үйл ажиллагааг хугацаанд нь гүйцэтгэж дуусгах явдал юм.

Төслийн санхүү болон худалдан авах ажиллагааг төслийн үндсэн хэрэгжүүлэгч болох НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан шууд захиран зарцуулж хэрэгжүүлдэг бөгөөд төслийн нэгж санхүүгийн үйл ажиллагаанд оролцдоггүй ба санхүүгийн тайлан тооцоо төслийн нэгжид ирдэггүй болно.

12. “Монгол улсын химийн бодисын зохистой менежментийг дэмжих замаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх мөнгөн усны сөрөг нөлөөллийг бууруулах нь” төслийн хүрээнд:

Дүгнэлт: Төсөл амжилттай хэрэгжиж төслийн зорилго, зорилт хангалттай биелэгдсэн. Мөнгөн ус агуулсан хаягдлын менежментийн журмын төсөл боловсруулагдсан боловч журамд заасан аюултай хог хаягдлын байгууламж байхгүй байгаагаас батлагдаагүй болно. Төсөл хэрэгжүүлэхэд БНСУ-ын Засгийн газрын харъяа уул уурхайн нөхөн сэргээлтийн МИРЕКО байгууллага хамтран санхүүжүүлэгчээр оролцож, бохирдлын судалгааг санхүүжүүлж гүйцэтгэсэн.

Ололт: Төслийн төлөвлөгөөнд анхнаасаа тусаагүй боловч улсын хэмжээнд хуримтлагдсан устгах шаардлагатай химийн бодис, түүний дотор мөнгөн ус болон мөнгөн ус агуулсан хаягдлыг агуулах зориулалтын байгууламж байхгүйгээс зориулалтын бус газруудад хадгалагдаж хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой эрсдэл бий болгож байгаа нөхцөл байдлыг төслийн удирдах зөвлөлөөр хэлэлцэж, НҮБАҮХБ-д хүсэлт тавьсанаар төслийн хүрээнд мөнгөн усны зориулалтын агуулах барьж байгуулан дээрх хаягдлыг төвлөрүүлэн цуглуулах ажил хийгдсэн.

Дутагдал: Төслийн санхүү болон худалдан авах ажиллагааг төслийн үндсэн хэрэгжүүлэгч болох НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан шууд захиран зарцуулж хэрэгжүүлдэг бөгөөд төслийн нэгж санхүүгийн үйл ажиллагаанд оролцдоггүй ба санхүүгийн тайлан тооцоо төслийн нэгжид ирдэггүй болно.

13. “Монгол улсад Монреалын протоколыг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх” төслийн хүрээнд: /8-р үе/

Зорилт 1. Хууль тогтоомж, журмын дагуу озон задалдаг бодисын хэрэглээнд хяналт тавих, хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх;

- ОЗБ-ыг импортлогч компаниудад ОЗБ-ыг жил тутам бууруулах квотын систем тогтоон хяналт тавин ажиллаж, ОЗБ-ын импортыг шат дараалан амжилттай бууруулсаар байна.
- HCFC хөргөх бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөрийн дагуу 2016 онд HCFC хөргөх бодисын импортыг 10 хувиар бууруулан 21 тонн бодис импортлохоор тогтоосон ба амжилттай мөрдөн ажиллав.
- Гаалийн байгууллагатай нягт хамтран ажиллаж байнгын мэдээ, мэдээлэл солилцож хамтын ажиллагаагаа бэхжүүлж байна.
- Хяналтын зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлж байнга хяналт тавьж, сургалт семинар зохион байгуулсны үр дүнд озоны давхаргад ээлтэй хөргөлтийн төхөөрөмж, орлуулах бодисын импорт, хэрэглээ байнга өсөн нэмэгдэж, энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд шинэ технологи нэвтрүүлж байна.
- БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 12 дугаар сарын 21-ны өдөр баталсан А-429 тоот тушаалд тогтоосон тоо хэмжээ, квотын дагуу ОЗБ болон орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжинд зөвшөөрөл олгон ажиллаж байна.
- Тайлан мэдээг цаг тухайд нь холбогдох яам, байгууллага, олон улсын байгууллагуудад тайлагнав.
- Монгол улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалтанд Дэлхийн дулааралд нөлөө бүхий зарим төрлийн HCFC бодисыг оруулах санал боловсруулж, танилцуулгын хамт холбогдох яаманд хүргүүлсэн нь 2012 оны 12 сарын 01-ний өдрийн ЗГ-ын 145 дугаар тогтоолоор батлагдаж тус тогтоолыг ОЗБ-т хяналтын зөвшөөрөл олгохдоо дагаж мөрдөж байна.
- Агаарын тухай хуулийн 25.1 хэсэгт “Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 1999 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл олгох журмыг” шинэчлэн боловсруулж, 2015 оны

3 дугаар сард 3 дахь удаагаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

Дутагдал, анхаарах асуудлууд: Засгийн газарт өргөн барьсан дүрэм, журам батлагдахгүй удаж байгаа нь зөвшөөрөл олгох болоод иргэдэд хүндрэл учруулж байна. Хөргөлтийн техникийн инженер, техникийн ажилтнуудын зөв зохистой засвар үйлчилгээ хийх чадавхийг үнэлэх стандарт боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ололттой тал: ОЗБ бүхий тоног төхөөрөмж импортлох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд ОЗБ, тэдгээрийн хор хөнөөл, озоны давхаргын хомсдолын байгаль болоод хүний эрүүл мэндэд нөлөөлөх хор хөнөөлийг тайлбарлах, ОЗБ-ыг оруулах бодис бүхий тоног төхөөрөмж импортлохыг ухуулан таниулах мэдээлэл сурталчилгааны ажил өргөн хүрээтэй явуулж байна.

Зорилт 2. HCFC хөргөх бодисыг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ололттой тал:

- Гааль, МХЕГ-ын хилийн мэргэжлийн хяналтын ажилтанууд, МХХАХ болон хөргөлтийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, XPS хөөсөнцөр хавтан үйлдвэрлэгч компаниуд бусад албан байгууллага, хэвлэл мэдээллийн сэтгүүлчдэд зориулан хэд хэдэн сургалтыг амжилттай зохион байгуулж, олон нийтийн сургалт сурталчилгааны ажлыг Озоны давхаргыг хамгаалах, HCFC төрлийн бодисыг бууруулах асуудалд төвлөрүүлэн хэрэгжүүлэв.
- Гаалийн болон хууль хэрэгжүүлэх ажилтнуудын ОЗБ-ын импортод хяналт тавих чадавхийг бэхжүүлснээр гаалийн байгууллага хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, эрсдлийн удирдлагыг гаалийн хяналтад нэвтрүүлэхдээ ОЗБ-ын импортын талаар Эрсдлийн түүх үүсгэж ажилласнаар хамтын ажиллагаа, чадавхийг бэхжүүлсний үр дүн гарч байна.

Хөргөлтийн техникийн инженер, техникийн ажилтнуудын зөв зохистой засвар үйлчилгээ хийх чадавхийг бэхжүүлэх;

- Төслийн хүрээнд МХХАХ-ны дэргэдэх “Мастер чадамж” сургалт судалгааны төвийг байгуулан ажиллаж байна.
- 2012 оны 5 сараас 2015 оны 8 сарын хооронд 140 гаруй хөргөлтийн техникчдийг чадавхижуулж гэрчилгээ олгов.
- Озоны давхаргыг хамгаалах олон нийтийн мэдээлэл сурталчилгааны ажилд мэргэжлийн холбоо болох МХХАХ-г татан оролцуулж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж ирэв.
- МХХАХ-той хамтран ажиллаж холбооны болон сургалтын төвийн үйл ажиллагаанд олон талын дэмжлэг үзүүлж байна.
- Хөтөлбөрийн хүрээнд Сургалтын төв байгуулан хөргөлтийн техникийн засварчин, техникч нарт зориулсан анхан болон чадамж ахиулах сургалтыг агааржуулалт, хөргөлтийн завсарчдад зориулан зохион байгуулж байгаа нь ОЗБ-ыг агаарт алдалгүй зөв зохистой засвар үйлчилгээ эрхлэх чадавхи олгохын зэрэгцээ, гэрчилгээжүүлж, эрх бүхий хөргөлтийн техникч, засварчидыг бий болгож байна. Ингэсэнээрээ ОЗБ агаарт алдалгүй зөв зохистой засвар үйлчилгээ эрхлээд зогсохгүй эцсийн хэрэглэгчдийн эрх ашигт нийцэх чанартай үйл ажиллагаа явуулж, эдийн засаг болоод ногоон хөгжил хувь нэмрээ оруулж байна.
- Хөргөлтийн засвар үйлчилгээ эрхэлдэг албан байгууллага, хөргөлтийн инженер, техникчдэд озоны давхаргын нимгэрэл, түүний хүний эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөл, озоны давхаргыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж болон ОЗБ-ыг орлуулах бодис бүхий байгаль орчинд халгүй шинэ техник технологийг нэвтрүүлж, зөв зохистой засвар үйлчилгээ явуулах талаар ухуулан таниулах үйл ажиллагаа явуулж байна.
- Озоны давхарга ба түүний үүрэг, нөлөө, озоны давхарга цоорсноос хүний эрүүл мэнд, ургамал, амьтан, байгальд учруулах хор уршиг, байгаль орчинд ээлтэй шинэ техник технологийг сонгох, зөвлөмж, мэдээллийн фото стикер самбарууд, гарын авлага, брошур гэх мэт олон нийтэд зориулсан тараах материалудыг хэвлүүлэв.

Зорилт 3. Олон нийтийн сургалт сурталчилгааны ажлыг озоны давхаргыг хамгаалах, HCFC төрлийн бодисыг бууруулах асуудалд төвлөрүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр ололттой тал:

- Озоны давхаргын нимгэрэл болон уур амьсгалын өөрчлөлтийн уялдаа холбоо, ОЗБ-ын хор хөнөөл, озоны давхарга, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөгүй шинээр нэвтэрч буй тоног төхөөрөмж, технологийн талаар мэдээлэл сурталчилгааны ажлууд, хурал, сургалтуудыг зохион байгуулав.
- Озоны давхарга ба түүний үүрэг, нөлөө, озоны давхарга цоорсноос хүний эрүүл мэнд, ургамал, амьтан, байгальд учруулах хор уршиг, байгаль орчинд ээлтэй шинэ техник технологийг сонгох зөвлөмж, мэдээллийн фото стикер самбарууд, гарын авлага, брошур гэх мэт олон нийтэд зориулсан тараах материалуудыг хэвлүүлэв.

**14. “Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих нь” төслийн хүрээнд:**

2016 онд нийт 2 удаа Азийн Хөгжлийн Банкнаас төслийн хэрэгжилтийн явцтай танилцаж үнэлгээ өгөх, зөвлөгөө, чиглэл өгч ажилласан. Уг ажилд БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудаас гадна АХБ-ны хөтөлбөр хариуцсан ажилтнууд, АХБ-ны Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газрын ажилтан, зөвлөх компани “НИРАС”-ийн удирдлагын төлөөлөл оролцсон. Төслийн нэгж дээр төслийн үндэсний захирал, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын (ОСХТ) холбогдох ажилтнууд уулзаж төслийн нэгжийн ажилтнуудтай санал солилцож, зөвлөгөө өгч ажилласан.

Дүгнэлт:Төслийн удирдах зөвлөлөөс хээрийн туршилтанд ашиглах тоног төхөөрөмж, төслийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэх аймгуудыг сонгох асуудлыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Техникийн туслалцааны энэхүү төслийн үйл ажиллагаа төлөвлөгөөнийхөө дагуу хэрэгжиж байгаа боловч төслийн багаас үл хамаарч зарим үйл ажиллагаа цаг хугацаандаа эхлэлгүй удаашрах, хойшлох асуудал гарч байна. Тухайлбал орон нутагт хийгдэх талбайн туршилтын ажил 2016 онд эхлэх байсан боловч гадаад худалдан авалт цаг хугацаандаа хийгдэж чадаагүйгээс шалтгаалан 2017 оны 4 сараас хийгдэхээр хойшлогдоод байна.

Ойн нөхөрлөлүүдийн эрх зүйн орчин тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг болж чадахгүй байна. Тухайлбал:одоогийн мөрдөж байгаа хууль тогтоомжоор ойн нөхөрлөлүүд зөвхөн унанги мод ашиглах эрхтэй. Судалгаанаас үзэхэд нөхөрлөлүүд унанги мод ашиглаж амьжиргаагаа сайжруулах, ойн тогтвортой менежмент нэвтрүүлэх боломж хараахан бүрдээгүй байна. Харин ойн нөхөрлөлүүд болзол, шаардлагыг хангах үндсэн арчилгааны огтлолын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага байна.

Дээрх асуудлууд төслийн хэрэгжилтэнд эрсдэл учруулаагүй бөгөөд ихэвчлэн санхүүжүүлэх талын дүрэм, журмын мөрдөлттэй холбоотой гэж үзэж байна.

**15. “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” төслийн хүрээнд:**

НЭЗТТ-ийн санаачлага нь 2017 онд дуусах тул цаашид хүрсэн үр дүн, эхэлсэн ажлыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, санхүүжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай. НЭЗТТ-ийн санаачлагад БОАЖЯ, ҮСХ, БХБЯ зэрэг олон яамд, агентлагууд оролцдог ба үйл ажиллагааны зохицуулатыг БОАЖЯ, яамдын төлөөлөгчдөөс бүрдсэн Техникийн хороо зохицуулдаг. Техникийн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай.

**16. “Усны салбарын менежментийг сайжруулах, усны эдийн засгийг хөгжүүлэх” төслийн хүрээнд:**

Сонгож авсан Улаанбаатар, Таван толгой, Нялга шивээ овоо бүсүүдэд байгаа усны эрэлтийг тооцож, ирээдүйд үүсэх эрэлтийг бага, дунд, их хувилбараар тооцон эрэлт хийлүүлэлтэд үүсэх зөрүүтэй байдлыг арилгахад шаардлагатай шийдлүүдийг усны эдийн засгийн тооцоо хийн шийдлүүдийг эрэмблэж, холбогдох талуудад (төрийн, хувийн, иргэний нийгмийн) хүргүүлсэн.

Одоогийн мөрдөж байгаа УЭЭЗ аргачлалыг сайжруулах, зарим тоо, статистик мэдээг оруулж сайжруулан үе шаттай хэлэлцүүлэг, саналуудыг холбогдох талуудад танилцуулав.

Монгол орны усны салбарын чадавхийг дээшлүүлэх, усны засаглалыг сав газрын түвшинд сайжруулах, оролцогч талуудын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх зэрэг ажлуудыг сав газрын захиргааны түвшинд хийсэн. Монгол улсын усны мэдээллийн санг санхүүжүүлж, одоо нээлттэй байдлаар цахим орчинд ажиллаж байна.

Олон талт оролцоог хангасан (Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоо), цаашид оролцогч талуудыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

17. “НҮБ-ын УАӨСК-ийн хэрэгжилтийн Үндэсний гуравдугаар тайлан илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх” төслийн хүрээнд:

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор төслийн эхлэх хугацаа хойшилж, БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А-118 тоот тушаалаар Байгаль хамгаалах санг төсөл хэрэгжүүлэх байгууллагаар томилсноор төслийн нэгжийг байгуулан, үйл ажиллагааг эхлүүлсэн. Улмаар төслийн удирдах зөвлөлийг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны 05 сарын 19-ны өдрийн А-205 тоот тушаалаар байгуулж, анхдугаар хуралдааныг 06 сарын 19-ны өдөр зохион байгуулсан. Тус хуралдаанаар төсөл, төслийн 2015-2017 оны ерөнхий төлөвлөгөөг танилцуулж саналыг нэгтгэсэн болно.

НҮББОХ нь санхүүгийн шинэ менежментийн системд шилжсэнтэй холбоотойгоор зөвлөх багуудыг сонгон шалгаруулах ажил тодорхой хугацаагаар хойшлоод байсан. Гэвч тайлан илтгэлийн үндсэн бүлгүүд болох дасан зохицох болон сааруулах чиглэлийн үнэлгээ, арга хэмжээний чиглэлийг боловсруулах зөвлөх багуудыг 2016 оны эхний улиралд багтаан сонгон шалгаруулалт хийж тайланг боловсруулах ажлыг эхлүүлсэн юм.

18. “НҮБ-ын УАӨСК-ийн Үндэсний 2 жил түтмын тайлан илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх” төслийн хүрээнд:

Төслийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэх арга хэмжээг зохион байгуулж тайланг 2016 оны 7-р сард санхүүжүүлэх талд буюу НҮББОХ-д хүргүүлсэн. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд БОАЖЯ-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба төслийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр гаргасан зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг БОАЖЯ-д тайлагнаж ажилласан. ХХИ-ийн хүрээнд байнгын мэргэжилтнүүдийн багийг бүрдүүлж ХХИ-ийн тооцоог тодорхой аргачиллын дагуу хийж эх мэдээ цуглуулах, холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, НҮБУАӨСК-ийн арга аргачиллын талаарх Үндэсний зөвлөхүүдийн чадавхийг дээшлүүлэх чухал хэрэгцээ шаардлага байна.

19. “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд:

Төсөл хэрэгжиж эхэлсэн хугацаанд албан боловсролын сургалтын хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн боловсрол(ТХБ), Тогтвортой хөгжил(ТХ), Ногоон хөгжил(НХ)-ийг үндэс суурийг тусгахад анхаарч амжилттай ажилласан бол 2017 онд орон нутгийн оролцогч талуудыг(сургууль, удирдлагын түвшин болон олон нийт) суралцах болон үйлдэхүйн үйл явцыг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх чиглэл рүү анхаарал хандуулах шаардлагатайг тодорхойлсон болно. Гол оролцогч талууд төслийн үр нөлөөг “өмчлөх”, өөрийн болгох нь (яамд, яамдын харъяа байгууллагууд) төслөөс гарсан үр дүнг тогтвортойгоор үргэлжүүлэх гол үндэс юм. 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээс хамааран бүтцийн өөрчлөлт хийгдэж, ялангуяа БСШУСЯ-тай хамтын ажиллагаа тодорхой хугацааны туршид удааширсан ба төслийн түнш хоёр яамны ажлын зохицуулалт хэсэг хугацаанд тасалдахад хүрсэн.

БСШУСЯ-ны тогтолцооны шинэчлэл ТХБ-д төвлөрсөн нь тодорхой бөгөөд БОАЖЯ-ны оролцоонд ТХ, НХ-ийн зарчим, арга хэрэгслийг ерөнхийд нь хэрэглэх хандлагатай бөгөөд цаашид хоёр яамны хамтын ажиллагаа, оруулах хувь нэмэрт ялгааг арилгах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

20. “Ус-Ногоон хөгжлийн зангилаа” төслийн хүрээнд:

Дараах ололттой талыг онцлон дүгнэв. Үүнд:

1. Мэдээллийн сан, тус төслийн зорилго, зорилт хүлээгдэж буй үр дүнгийн талаар төсөлд оролцогч талууд нэгдсэн ойлголтод хүрсэн. Цаашид мэдээлэл солилцох, хамтран ажиллах тал дээр талууд саналаа солилцсон.
2. Цуглуулах мэдээллүүдийг оролцогч талуудын санал дээр тулгуурлан ангилан, тэдгээрийг шат дараалалтай цуглуулах, бүрдүүлэх төлөвлөгөөг, мэдээллийн санг цаашид 2020 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний хамтаар гаргаж ирсэн.
3. Хэдийгээр гадаргын ус, газрын доорх устай холбоотой ихэнх мэдээлэл, мэдээллийн нууцлал болон мэдээллийг үнэлэх асуудлаас хамааран олон нийтэд ил тавих боломжгүй боловч, нэн шаардлагатай гэж ангилагдсан, гадаргын ус, газрын доорх ус, ус ашиглалттай холбоотой мэдээллүүдийн 85% мэдээллийн санд байршуулах бүрэн боломжтой болсон.
4. Нэн шаардлагатай гэж ангилагдсан, гадаргын ус, газрын доорх ус, ус ашиглалттай холбоотой мэдээллүүдийн 65% чанарыг шалгав.



Дутагдал: Улс төрийн тогтворгүй байдал буюу 2016 оны 6 сард болсон УИХ-ын сонгуулийн дараа Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөр хамтран ажилладаг талуудын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байсан нь ДДНХБ-ын хувьд бэрхшээлтэй байсан. Учир нь төрийн албан хаагч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлын үр дүн буурах, дахин зохион байгуулах, цаг алдах, зардал нэмэгдэх гэх мэт асуудлууд гарч байсан бөгөөд нөгөө талаар ДДНХБ урт хугацаандаа олон янзын оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах туршлага болсон болно.

**21. Монгол орны усны аюулгүй байдлын үнэлгээ” төслийн хүрээнд:**

Энэ төслийг хэрэгжүүлэгч нь БОАЖЯ боловч Шинэ Зеландын ANZDEC зөвлөх компани АХБ-тай шууд гэрээ хийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа учир санхүүжилтийг захиран зарцуулах эрх нь энэхүү компанид байдаг. Төслийн бичиг баримтаар төсөл 2015 оны 7 сарын 15-д эхлэх байсан ч 2015 оны 11 сард үйл ажиллагаа нь эхэлсэн тул хугацаа хоцорч байгаа ч ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөөгүй болно.

**22. “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд:**

Төсөл хэрэгжиж буй Завхан, Ховд, Увс аймагт орон нутгийн зохицуулах хороодыг байгуулан тэдгээрийг идэвхижүүлэх сургалт, уулзалт, туршлага судлах аялал зохион байгуулсан нь орон нутгийн төрийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдийн газрын тогтвортой менежмент, дүйцүүлэн хамгаалал, экологийн бүс нутгийн үнэлгээ, байгаль орчны үнэлгээ, аудит, бэлчээрийн менежментийн талаарх мэдлэг, ойлголт эрс дээшилсэн. Түүнчлэн орон нутагт талуудын ажлын уялдаа, мэдээлэл солилцоо сайжирч, 6-8 байгууллага хамтын ажиллагааны анхны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн болно.

**23. “Монгол орны хүлэрт намгийн стратегийн төлөвлөгөө” төслийн хүрээнд:**

Манай орны хүлэрт намаг эдүгээ хүртэл хамгийн бага судлагдсан юм. Энэ төслийн хүрээнд манай улсын тэргүүн зэргийн ач холбогдолтой намгийн орчин үеийн төлөв байдал тархац, талбай, тоо чанарын талаас нилээд нарийн судлагдаж анхдагч үнэ цэнэтэй мэдээ, материалтай болов. Судалгааны нарийн багаж, төхөөрөмжтэй болон чадавхи үлэмж дээшлэн, үндэсний намаг судлаач хүний нөөцтэй болж буй нь нэг чухал ололт юм.

Намгийг туулах чадвартай сайн машин, механизм дутагдалтай байлаа.

**24. “Монгол улс ногоон хөгжилд шилжих нь” төслийн хүрээнд:**

ДДНХБ-ын 2015-2016 онуудад төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэл 100% хувьтай хэрэгжсэн бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай үр дүнтэй нягт хамтран, мэдээлэл солилцох, харилцан ойлголцож ажиллах явдал ажлын гүйцэтгэлд маш чухал нөлөөтэй байв. Төр, хувийн хэвшил, олон нийтийн зүгээс ногоон хөгжил, ногоон технологийн талаарх ойлголт харьцангуй дээшилсэн бөгөөд Засгийн газрын зүгээс байгаль орчинд ээлтэй технологи, үйл ажиллагааг ач холбогдол өгөн дэмжих хандлага нь харьцангуй нэмэгдсэн болно.

Бэрхшээл: Улс төрийн тогтворгүй байдал буюу 2014 оны 10 сараас 2016 оны 12 сарын хооронд бид 4 өөр Засгийн газрын бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Засгийн газар солигдох бүрд бидний хамтран ажилладаг талуудын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байсан нь ДДНХБ-ын хувьд бэрхшээлтэй байсан. Учир нь төрийн албан хаагч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах ажлын үр дүн буурах, дахин зохион байгуулах, цаг алдах, зардал нэмэгдэх гэх мэт асуудлууд гарч байсан. Гэвч энэ нь нөгөө талаар ДДНХБ урт хугацаандаа олон янзын оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах туршлага болсон.

Зураг төслийн магадалгаа, холбогдох зөвшөөрөл авах ажиллагааны үйл явц, бүрдүүлэх баримт бичиг ойлгомжгүй эсхүл тодорхой бус учраас холбогдох зөвшөөрлийн ажлыг авахад цаг хугацаа их шаардаж байна. Улсын төсвийн хүрэлцээгүй байдлаас үүдэн санал болгож буй ногоон, дэвшилтэт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсвийн хөрөнгө хуваарилах нөөц бололцоо бага байна. Үүнээс үүдэн жишиг ногоон цэцэрлэгийг барьж байгуулахад санхүүгийн бусад эх үүсвэрийг олох хэрэгцээ үүссэн.

**25. Уул үүрхэйн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хүрээнд:**

Говийн бүсийн “Газрын доорхи усны менежментийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлснээр сав газрын хэмжээнд Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд сав газрын нийт нутаг дэвсгэрийг хамарсан уст цэгийн тоо бүртгэл, ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл, судалгаа, нийгэм эдийн засгийн болон байгаль орчны суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэсний зэрэгцээ

усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, аж ахуйн нэгж, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр олон ажлыг хийж гүйцэтгэв. Сум орон нутгийн удирдлага, иргэдийг усны талаарх мэдээллээр тогтмол хангаж хамтран ажилласан.

Говийн бүсийн “Газрын доорхи усны менежментийг бэхжүүлэх, Сав газрын захиргааны боловсон хүчнийг чадавхижуулах” зорилтуудыг хэрэгжүүлснээр

1. Сав газрын хэмжээнд усны тухай асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэх боломж бүрдсэн
2. усны нөөц бага говь нутгийн хэмжээнд газрын доорх усны хяналтын мониторингийн сүлжээг байгуулсан
3. Сав газрын мэргэжилтнүүдийг чадавхижуулан орон нутгийн удирдлага, иргэдийг мэдээллээр хангаж хамтран ажиллаж байна.
4. Сав газрын хэмжээнд гадаргын усны судалгаа, уст цэгийн тооллогыг ажлыг иж бүрэн хийж гүйцэтгэсэн
5. 2014-2016 онд Улсын төсөвт Усны нөөц ашигласны төлбөрт нийт 42,2 тэрбум.төг төвлөрүүлсэн байна. 2016 онд 20,5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Говийн бүсийн газрын доорх усны эвдэгдсэн болон байгалийн горимын хэмжилтийг хоногт 4 удаа буюу 6 цагийн давтамжтайгаар авч мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна. Усны мэдээллийн нэгдсэн санг Монгол орны хэмжээнд бүх сав газрын захиргаад ашиглаж мэдээлэл нэгтгэх боломжтой байхаар зохион байгуулсан. ([www.groundwater.mn](http://www.groundwater.mn)). AquaSys2015 програм бүрэн ажиллагаанд орж 5013 портоор өгөгдөл хүлээн авч MySQL-HydroDb баазруу мэдээлэл оруулдаг болсон. Groundwater Monitoring System вэб бүрэн ажиллагаанд орсон. Эдгээр бүх тохиргоог өөр сервер шилжүүлэн суулгаж ашиглах чадвартай болсон.

Ашиглалтын 3 талбайгаас нийт 250л/с усыг 36 ашиглалтын худгаар 25 жилийн хугацаанд ашиглахад уст давхаргын зөвшөөрөгдөх бууралтын хэмжээнд байх үр дүн гарсан. Цаашид загварыг газрын доорх усны хяналт-шинжилгээний олон жилийн хэмжилтийн мэдээллээр тохируулга хийж загварын үр дүнг нарийвчилна.

Ололт: Санхүүжилт, багаж, тоног төхөөрөмжийн хангалт сайн байдаг ба сав газрын өнцөг булан бүрт хүрч ажиллах боломж бололцоог төслийн санхүүжилт олгож байна. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи, программ хангамжийг авч ашиглах боломж бүрдсэн нь судалгаа, мэдээллийг нарийвчлал, баталгаажилтийг өндөрсгөж байна.

Анхаарах асуудал:

- Төсөл хэрэгжүүлэх санхүүжилт, хугацааг сунгах;
- Ус ашиглах зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах үйл ажиллагаатай ходбогдон зарим бэрхшээлтэй асуудал тулгарч байна.
- “Эрдэнэс таван толгой” ХХК, “Таван толгой” ХК зэрэг аж ахуйн нэгжүүдийн Ус ашиглуулах дүгнэлтэд уурхайгаас шавхан зайлуулахаар тусгагдсан усны хэмжээ бодит байдал дээр шавхан зайлуулсан уснаас хэт өндөр байна. Тухайлбал: “Таван толгой” ХК-ийн 2016 оны дүгнэлтэд 1,4 сая.м<sup>3</sup>/жил ус шавхан зайлуулахаар тусгагдсан боловч бодит байдал дээр тус онд 40,3 мянган.м<sup>3</sup>/жил шавхан зайлуулсан зэрэг усны нөөц ашигласны төлбөр ногдуулалт, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байгаа тул дүгнэлтийг бодит байдалд нийцүүлэн гаргах шаардлагатай.
- Хууль эрх зүйн хүрээнд: Усны тухай хуулийг шинэчлэн боловсруулах, холбогдох зүйл, заалтын хүрээнд гарах ёстой тогтоол шийдвэрийг бүрэн гаргаж хэрэгжилтийг хангах. Тухайлбал:Тус хуулийн 3.1.2-т/Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална/ гэж заасан бөгөөд журам батлагдаагүй байгаа нь уг заалтыг зөрчсөн ус ашиглагч нарт хариуцлага тооцох, нөхөн төлбөр ногдуулах нөхцөлийг хангахгүй байна.
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль батлагдсан боловч холбогдох тогтоол, журам гараагүй байгаа тул хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

26. “Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төслийн” хүрээнд: Төсөл хэрэгжүүлэх явцад гарсан ололт, амжилт гарсныг тэмдэглэж байна. Үүнд:Төслийн удирдах

хорооны анхдугаар хурлаас баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 33 ажлаас 27 ажил нь бүрэн биелэгдэж 6 ажил хойшилсон, төслийн хэрэгжилт 82 хувийн биелэлттэй буюу хангалттай байсан.

- Төслийн менежментийн хувьд: Төслийн тусгай болон, дэд нээх, төсөв санхүүжилтээ татаж авах, Төслийн Удирдах хороо, Төслийн Удирдах болон Хэрэгжилтийн нэгжийг тус тус байгуулан үйл ажиллагаагаа зохих түвшинд зохион байгуулсан.
- Санхүүгийн зорилтын хувьд: 2016 онд зарцуулахаар төлөвлөсөн нийт санжүүжилтийн 75 хувийг зарцуулан боломжийн үнэлгээ авсан.

Анхаарах асуудал: Улсын төсөвт төслийн Монголын талын хувь хандивыг суулгах,

- Сонгуулийн жил эхэлсэн төслийн хувьд үйл ажиллагааг хугацаанд нь зохион байгуулахад гарах хүндрэлээс сэргийлэх,
- Яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнөөс Үнэлгээний ажлын хэсэгт өөрчлөлт орох, мөн үнэлгээний хороонд ажиллах АЗ сертификаттай хүн байхгүй, сургалтад суух ажлын болон санхүүжилтийн боломж байхгүй зэрэг асуудлууд гарч байсныг цаашид анхаарах шаардлагатай юм.

#### 27. Ногоон зээлийн сан төслийн хүрээнд:

Ололттой тал: Төрийн байгууллага болон хувийн банкуудын идэвхитэй оролцоо сайжирсан.

- Сан байгуулах чиглэлээр төрөөс барих бодлого тодорхой бөгөөд бодит дэмжлэг үзүүлэх боломж бүрдсэн.
- Хөрөнгө оруулалт татах боломж бүхий сангийн бүтэц, санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой болсон.
- Ногоон зээлийн зах зээлийн боломж өргөн бүрдсэн.

Дутагдалтай тал: Макро эдийн засаг, ерөнхий хөрөнгө оруулалтын тогтворгүй орчин сэргөөр нөлөөлөх талтай,

- Хөрөнгө оруулалтын сангийн тухай болон бусад холбогдолтой хууль эрх зүйн орчны тодорхой бус байдал, Ногоон уур амьсгалын сан болон Засгийн газар хоорондын хамтын ажиллагаа сул зэрэг дутагдалтай тал байна.

#### 28. Төслийн загвар болон бэлтгэл: Боловсрол ба байгаль орчны салбарын ногоон ТХХТ-ийн/концессын төслүүдийг бэлтгэх, хэрэгжүүлэх төслийн хүрээнд:

Ололттой тал: Монголын үндэсний ТХХТ-ийн хөтөлбөрийг хариуцан ажиллаж НХОУ-ний Монгол дах гол түнш байгууллага болох Хөрөнгө Оруулалтын Газартай үргэлжилсэн хэлэлцүүлэг, уулзалтуудын үр дүнд яамд болон бусад холбогдох оролцогч талуудыг уялдуулсан төслийн ажлын хэсэг байгуулагдсан. Төрийн байгууллагуудын хамтран ажиллах уялдаа холбоог сайжруулсан. ТХХТ төслүүдийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд ногоон хөрөнгө оруулалтын давуу тал, ТХХТ-д шингээж өгөхийн ач холбогдолыг ойлгон хүлээн авч, загвар төслүүд дээр хэрэгжүүлэхээр шийдэн хамтран ажиллаж байна.

Дутагдалтай тал: Монгол Улсын Засгийн Газрын бүтцийн өөрчлөлтийн улмаас төслийн хамрах хүрээг баталгаажуулах үйл явц төлөвлөсөн хугацаанд хийгдэлгүй хойшлогдсон болно. 2015 оны 6 сард төслийн бэлтгэл ажил дуусаж ногоон дэд бүтэц болон ТХХТ-ийн орчинг сайжруулах төслийн ажлын төлөвлөгөөн дээр хамтран ажиллах албан ёсны захидлыг Монгол улсын Засгийн газраас хүлээн авсанаар төслийн ажил 2015 оны 8 сард эхэлсэн болно.

Төслийн зорилтот үр дүнд 2016 онд багтаан хүрсэн боловч загвар төслийг сонгон шалгаруулах ажил 2016 онд хийгдэхгүй хойшилсон. Засгийн газрын бүтцэд удаа дараа өөрчлөлт орж, түнш байгууллагууд татан буугдах, хэрэгжүүлэгч үүрэг функц солигдох зэрэг тогтвортой бус байдал нь нөлөөлсөн гэж дүгнэж байна.

#### 29. Монгол орны заган ойг нөхөн сэргээх чадамжийг бүрдүүлэх төслийн хүрээнд:

Заган ой бүхий 6 аймгийн Сум дундын ойн ангиуд заган ойг нөхөн сэргээх талаар туршлага солилцон, шаардлагатай мэдлэг, мэдээлэл авсан. Говь-Алтай аймгийн Сум дундын ойн анги заган ойг нөхөн сэргээх зориулалтын тоног төхөөрөмжөөр хангагдсан.

Сум дундын ойн ангиудад мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай. Сум дундын ойн ангиуд болон заган ойг ашиглан амьдардаг иргэдэд заган ойн ач холбогдол, түүний тогтвортой байдлыг хангах чиглэлээр сургах, мэдээллээр хангах шаардлагатай байна.

#### 30. Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төслийн хүрээнд:

СЕСМИМ болон МЕРИТ төслүүд өөр хоорондоо ялгаатай үйл ажиллагаа явуулж байгаа өөр зорилготой төслүүд гэдгийг ойлгуулах зорилгоор харилцаа холбооны арга дээр хамтран ажилласан. Засгийн газрын хамтран хэрэгжүүлэгч болон бусад оролцогч талуудад төслийн хүрээг тодорхойлох зорилгоор илтгэл болон мэдээллийн чанартай материалууд хүргүүлэхээр ажиллаж байна.

### 31. Байгаль орчны бохирдлыг бууруулахад но-хау дамжуулах төслийн хүрээнд:

Төслийн жилийн төлөвлөгөөний хугацаа 2017 оны 3 сарыг дуустал бөгөөд төлөвлөгдсөн ажлууд зорилтуудынхаа хүрээнд хийгдэж байна. Дараах амжилттай хэрэгжүүлсэн ажлуудыг онцлон тэмдэглэж байна. Үүнд:

- Эрчим хүчний стратеги болон Санхүүгийн сургалт- Албертагийн Их Сургууль, /7 дугаар сар/
- Олон улсын шилдэг туршлагын семинар, “Discover Mongolia” хурлын үеэр семинар зохион байгуулсан./9 дүгээр сар/
- Уурхайн хаалтын семинар/9 дүгээр сар/
- СЕСМИМ төслийн Байгаль орчны аудит/ БОНБУ, уурхайн хаалт, орлогын удирдлага, тусгай зөвшөөрөл, кадастрын ажлын хэсгийг байгуулсан./9 дүгээр сар/
- Уурхайн хаалт, санхүүгийн баталгааны талаарх Канад улсын туршлага судлах аялал. Энэ үйл ажиллагааны үндсэнд салбарын тогтвортой хөгжлийг бий болгох уурхайн хаалт, санхүүгийн баталгаа, байгаль орчин, нийгэм, эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ, ТЭЗҮ, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон бусад холбогдолтой бодлогын хүчин зүйлсийг багтаасан шинэ уул уурхайн хууль боловсруулах санаачлагыг Монгол Улсын Засгийн газар гаргасан.
- Шинэ Уул уурхай хуулийн ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, ажлын хэсэг уул уурхайн хуулийн төсөл боловсруулсан бөгөөд СЕСМИМ төсөл 2017 онд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ. /11/12 дугаар сар/
- БОНБУ-ний чадавхи бэхжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан./11 дүгээр сар/
- Монгол болон Канадын олборлох салбарын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгийн бүтээгдэхүүн боловсруулж, судалгаа хийх НҮБ-ийн Ногоон хөгжлийн хөтөлбөрийн дадлагажигч ажилд авсан./12 дугаар сар/
- Сангийн яамны 3 мэргэжилтэн Канадад Ирээдүйн Өв Сангийн сургалтанд хамрагдсан./12 дугаар сар/
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Кадастрын хэлтэсд сургалт болон техникийн туслалцаа үзүүлж байгаа бөгөөд газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах, дроны хэрэглээ, зураглал сургалтууд болон кадастрын бодлогын шинжилгээ явагдаж байна. Кадастрын хэлтсийг дэмжих зорилгоор МЕРИТ төсөлтэй хамтран серверүүд суулгана. АМГТГ болон холбогдох газруудын нэгдсэн кадастрын мэдээллийн систем байгуулах төлөвлөгөөтэй.

Одоогийн байдлаар алдаа дутагдал гараагүй, зарим хойшлогдсон ажил дараа ондоо багтан бүрэн хэрэгжиж байгаа бөгөөд төсөл амжилттай хэрэгжиж байна.

Анхаарах асуудал: Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт, тогтворгүй байдлаас хамааран БОАЖЯ-тай хамтран ажиллахад хүндрэлтэй байсан.

- Яамдуудтай хамтран ажиллах: СЕСМИМ төслийн үйл ажиллагаа нь зөвхөн гурван яамаар хязгаарлагдахгүй бөгөөд эдийн засгийн хямрал, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт, Яамдын бүтэц, орон тоо, мэргэжилтнүүд, хамтран ажиллагсад өөрчлөгдөж, шинэ шийдвэр гаргагчид болон мэдлэг, ур чадварын түвшин өөр өөр шинэ ажилчид томилогдсон нь хүндрэлтэй байна.

Ололттой тал: Монгол улсын хүн амд ихээр аюул занал учруулах эрсдэлтэй экологийн болон химийн бохирдлын асуудлыг хөндөж, хэрхэн шийдвэрлэх арга замыг Монголын мэргэжилтнүүдэд зааж сургаж байгаагаараа давуу талтай юм.

- Харгиа цэвэрлэх байгууламжийн бохирдлыг цэвэрлэх, сэргээх төслийг Монголд хэрэгжүүлж байсан туршлагатай ДЕКОНТА ХХК нь энэ чиглэлийн ажлыг Европ, Ази, Африкийн орнуудад байнга гүйцэтгэдэг мэргэшлийн нэр хүндтэй байгууллага болохыг тэмдэглэх нь зүйтэй.
- Энэ төрлийн бохирдлыг хэрхэн шийдвэрлэх мэргэжлийн чадавх Монголчуудад бий болсноор хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх хангагдах юм.
- Цаашлаад төслийн хүрээнд Монгол улсын холбогдох хууль тогтоомжид оруулбал зохих өөрчлөлт, шинэчлэлтүүдийг санал болгосон зөвлөмж боловсруулж өгсөн юм.

- НҮБХХААБ-аас пестицидийн бохирдлыг судалж шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжих үндсийг тавьснаараа ач холбогдолтой юм.

Дутагдалтай тал:

- Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам, уул уурхайн хууль бус үйл ажиллагаанд нэрвэгдэж буй газар нутаг өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа тул төслийн хүрээнд бүх бохирдсон талбайг хамарч судлах, цэвэрлэх боломж хомс юм. Иймд Монголын төрийн байгууллага асуудлыг шийдвэрлэхэд хичээн ажиллах нь зүйтэй.
- Цаашид Монголын тал “Бохирдсон газрын бүртгэл, мэдээлийн систем”-ийг хөгжүүлэх /жишээлбэл НАТО-гийн төслийн үр дүнг нэмж оруулах эсвэл холбох/, хэрэглээнд өргөн нэвтрүүлэх буюу аймаг ба нийслэлийн байгаль орчны байцаагч, мэргэжлийн хяналтын байцаагч нар мэдээлэл нэмж оруулах, өдөр тутамдаа хэрэглэх боломжийг бүрдүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай байна.
- Монголын тал Булганы бохирдсон газраас цэвэрлэн авч битүүмжилсэн хаягдлыг агуулах сав гаргаж өгөх үүрэгтэй. Агуулах нь цаг агаарын аливаа нөхцөл байдлаас хамгаалсан хүчитгэсэн хамгаалалттай, битүү шалтай, гадны хүн орохоос хамгаалсан хашаа хамгаалалттай байх ёстойг харгалзан үзэж хаана хэрхэн хадгалах газрыг яаралтай зааж өгвөл зохино. Учир нь энэ нь 2017 онд хийгдэх гол ажил юм.
- Монголын засгийн газар ийм төрлийн хортой, аюултай хаягдлыг булшлан устгах тусгай зориулалтын ланд рефилл байгуулах санаачлагыг хэрэгжүүлэх замаар “Хог хаягдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангах тал дээр илүү анхаарах шаардлагатай байна.
- Түүнчлэн мэргэжлийн байгууллагын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэ төрлийн бохирдлыг судлах ба цэвэрлэх асуудлыг хөндсөн өөр бусад донор байгууллагын төсөл хөтөлбөр нэмж хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих нь зүйтэй гэж үзэж байна.

### **Тав. Дүгнэлт**

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй **нийт 31 төслийг** хяналтад авч, хэрэгжилтийн гүйцэтгэлд үнэлгээ өгөв.

2016 оны жилийн эцсийн байдлаар ерөнхий гүйцэтгэл **88.1 хувьтай** буюу **4.4 оноотой** үнэлэгдэж, 4 төсөл 100% буюу бүрэн хэрэгжсэн, 11 төсөл 90 хувьтай, 13 төсөл 70 хувийн биелэлттэй, 1 төсөл 50 хувийн биелэлттэй дүгнэгдэж, гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулахад **0.7 хувийн өсөлттэй** дүгнэгдэв. Үнэлгээний дүнг хавсралт 1-д харуулав.

Энэхүү үнэлгээний дүн нь гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийн өмнөх онтой харьцуулахад 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын төсвийн хүндрэл, хөрөнгө санхүүгийн хямралаас хамааран зарим ажил удаашралтай боловч олон улсын байгууллагын тусламж дэмжлэгээр төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ахиц гарсан эерэг үзүүлэлттэй дүгнэгдлээ.

### **Зургаа. Зөвлөмж**

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй нийт 31 төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, зорилт үр дүнгийн хүрэх түвшинтэй уялдуулан хэрэгжилтийг ханган, гүйцэтгэлд анхаарч, тодорхой үр дүнд хүрч байгаа ч цаашид анхаарах шаардлагатай санал, зөвлөмжүүдийг томъёолбол:

1. Гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурь үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлон батлуулж, мөрдөж хэвших,

2. Тухайн жилийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг тодорхой тоон үзүүлэлт, баримтад тулгаарлан үр дүнд суурилсан хяналт үнэлгээ хийх нөхцлийг бүрдүүлэх, тайлагнахад онцгойлон анхаарах,

3. Төслийн хэрэгжилтийн явцын болон үр суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэвших, гүйцэтгэлийн болон санхүүгийн зарцуулалтын явцад нэгж, газрууд хяналт тавьж, хөтөлбөрийн үр дүн, ач холбогдолыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах,

4. Зарим улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд санхүүгийн хүндрэлээс шалтгаалан тасарч, удааширч байгааг анхаарч, цаашид төлөвлөлтөд онцгойлон анхаарах,

5. Төслийн үр нөлөө, ач холбогдлыг холбогдох нэгж бүрээр гарган дүгнэх, нэгтгэн тайлагнаж хэвших шаардлагатай бөгөөд төслийг хариусан нэгж, зохицуулагчид төслийн хэрэгжилт, үр дүнг тайлагнах асуудлаар бүх шатны байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, төслийн хэрэгжилтийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хуулийн хугацаанд зөв, оновчтой, дэлгэрэнгүй тайлагнаж хэвшихэд онцгойлон анхаарах,

6.Төслийн тухайн жилд батлагдсан төсөв, төлөвлөгөөний заалт бүрээр хэрэгжилтийг тайлагнан, дүгнүүлэх, ил тод нээлттэй байх, төлөвлөлт-тайлагналт-дүгнэлт гурвалсан холсоог хангаж ажиллах,

7. Төслийн хэрэгжилтийн үр дүнд цаг үеийн болон эдийн засаг, нийгмийн, шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлсэн, үр ашигтай, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хөгжүүлэхэйц байх шаардлагатай бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэх,

8. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэл, судалгаатай урьдчилан зөв тооцож, бүх шатны буюу орон нутаг, хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд санхүүжилтийг зөв оновчтой зарцуулах, хариуцлагатай, үр дүнтэй ажиллахыг үүрэг болгох,

9. Улсын хэмжээнд нийт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн нэгдсэн үнэлгээ тайланг дүгнэх, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, олон нийтэд үр дүнг ил тод тайлагнах, тэдгээрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл сурталчилгааг явуулах, иргэдэд сурталчлан таниулах, хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, бүх түвшинд мэдээллийн үнэн бодит байдлыг хангасан, тоон мэдээллийг чанарын түвшингээр баталгаажуулсан байх,

10. Гадаадын буцалтгүй тусламжаар хэрэгжиж дуусч буй төслийн хэрэгжилтийн эцсийн тайланг нээлттэй, ил тод хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх, үр дүнг бататгах, цаашдын тогтвортой хэрэгжүүлэх үйл ажиллагааг ханган, үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

